



**МОНГОЛЫН САГСАН
БӨМБӨГИЙН ХОЛБОО ТББ**

1016245, Улаанбаатар хот, Хан-уул дүүрэг,
1-р хороо, Чингисийн өргөн чөлөө
Монголын Үндэсний Олимпын хороо
Утас: 9918

2022.04.07 № 08
танай _____-ны № _____-т

**САГСАН БӨМБӨГИЙН
АХМАДЫН ТӨЛӨӨЛӨЛД**

**Бүх гишүүдийн хуралд төлөөлөгч
оролцуулах тухай**

“Монголын сагсан бөмбөгийн холбоо” ТББ /цаашид “Холбоо” гэх/-ын дүрмийн 6.4-т зааснаар Бүх гишүүдийн ээлжит хурал хуралдаагүй, мөн дүрмийн 6.5-т зааснаар ээлжит бус хурал зарлан хуралдуулах шаардлагын хүрээнд Тэргүүлэгчид /Удирдах зөвлөл/-ийн 2022 оны 4 дүгээр сарын 06-ны өдрийн хурлаар Бүх гишүүдийн ээлжит бус хурлыг 2022 оны 4 дүгээр сарын 20-ны өдрийн 14:00 цагт Скай Ресортын “Хүн” театрт зарлан хуралдуулахаар санал нэгтгэйгээр шийдвэрлэж, тус хурлын төлөөлөгчдийн тоог тогтоосон болно.

Иймд Та бүхэн дор дурдсан тооны хүнийг Холбооны Бүх гишүүдийн хурлын төлөөлөгчөөр томилон ажиллуулах боломжтой байх тул холбогдох хүсэлтийг албан бичгээр төлөөлөгч нарын нэрс, мэдээлэл бүхий Хавсралтад заагдсан хүснэгтийн дагуу 2022 оны 4 дүгээр сарын 15-ны өдрийн 18:00 цагаас өмнө цахим болон цаасан хувилбараар Бүх гишүүдийн ээлжит бус хурлыг зохион байгуулах үүрэг бүхий Ажлын хэсэгт ирүүлэхийг үүгээр мэдэгдэж байна.

Холбооны нэр	Бүх гишүүдийн хуралд оролцуулах төлөөлөгчдийн тоо
Ахмадын төлөөлөл	40 хүн

Та бүхэн төлөөлөгчдийг томилохдоо хүйсийн эрх тэгш төлөөллийг оролцуулах талаар тус бүрнээ анхаарч ажиллахыг хүсье.

Жич: Бүх гишүүдийн ээлжит бус хурлыг 13:00 цагт төлөөлөгчдийн бүртгэлийг хийж, мандат олгох учир төлөөлөгчдийг цагаа зөв тооцоолж, иргэний үнэмлэхтэй хуралдаа хоцролгүй оролцуулахыг хүсч байна.

Утас: Ажлын хэсэгтэй холбоо барих утас- 88103955

Хаяг: Сүхбаатарын дүүргийн 8 хороо, Сэнтрал Тауэр 16 давхарт

Цахим хаяг: basketballmongolia@gmail.com

ЕРӨНХИЙЛӨГЧ



Ц.ЦЭВЭРБАЛ